



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 7 сарын 08 өдөр

Дугаар 77

Эрдэнэт

Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх гудамж,
зам хамрах хүрээ, түр саатуулах хашаа,
зогсоолын нийт талбайн хэмжээ, чирэгч, ачигч
автомашины тоо тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4 дэх заалт, Хууль зүйн сайдын 2015 оны А/190 дүгээр тушаалын 02 дугаар хавсралтаар батлагдсан "Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

- 1.Аймагт тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх хашаа /байр/-ны тоог хоёр байхаар тогтоосугай.
- 2.Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх үйл ажиллагаа явуулах гудамж зам, хамрах хүрээг хавсралтын ёсоор баталсугай.
- 3.Аймгийн хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, түгжрэл саатлыг бууруулах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор өглөөний 07.00 цагаас оройн 19.00 цагийн хооронд Монгол улсын Замын хөдөлгөөний дүрэмд заасан хориглосон газарт зогсож, бусдын хөдөлгөөнд саад учруулсан тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлсүгэй.
- 4.Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллага тус бүрийн түр саатуулах хашаа /байр/-ны зогсоолын нийт талбайн хэмжээ /ил болон битүү зогсоолын хүрэлцэхүйц талбайтай/ 4000 м²-аас багагүй, зориулалтын чирэгч, ачигч автомашин /Хууль зүйн сайдын 2015 оны 190 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан журмын 3 дахь хэсгийн 3.10.1 дэх заалтад заасны дагуу ачих шаардлага хангасан/-ы нийт тоо 2-оос доошгүй байхаар тус тус тогтоосугай.
- 5.Энэхүү тогтоолыг 2016 оны 07 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Б.МЯГМАРСҮРЭН

00100205